УВС АЙМГИЙН БӨХМӨРӨН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХОТГОР” ХХК-ИЙН “НҮҮРСТ ХОТГОР” НЭРТЭЙ ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: MV-001441, MV-014442, MV-020853 /

2025 он

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 4

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 4

1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ 5

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 7

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ 7

2.2. ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ 7

2.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГАЗРЫН ГАДАРГА 9

2.4. УУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙ ШИНЖ, ОНЦЛОГ 9

2.5. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ЧАНАР 10

2.6. УСАН ОРЧИН 11

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ 12

2.8. ХӨРСНИЙ ХИМИ, ФИЗИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ 13

2.9. ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН БОХИРДОЛ 14

2.10. УРГАМЛАН НӨМРӨГ 14

2.11. АМЬТНЫ АЙМАГ 15

2.12. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ 16

2.13. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 17

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 19

3.1. ТӨСЛӨӨС ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ 19

3.2. АГААРЫН ЧАНАРТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 19

3.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 19

3.4. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 19

3.5. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ 19

3.6. АМЬТНЫ АЙМАГТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 19

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 21

3.7. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ 25

3.8. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 30

3.9. ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 31

3.10. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 31

3.11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 33

3.12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 37

3.13. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 31

3.14. БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ 33

3.15. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл 4

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол 4

Хүснэгт 3. , MV-014442, MV-020853 тоот тусгай зөвшөөрлийн талбай дахь анх батлагдсан нөөцийн хэмжээ 6

Хүснэгт 4. Нүүрст хотгорын ил уурхайн уулын ажлын төлөвлөлт 6

Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн 10

Хүснэгт 6. "Хотгор"ХХК-ний гүний худгийн усны шинжилгээний дүн 12

Хүснэгт 7. Ямаатын голын усны унд ахуйн шинжилгээний дүн 12
Хүснэгт 8. Хөрсний химийн үндсэн шинжийн үзүүлэлтүүд 13
Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүн 14
Хүснэгт 10. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн 14
Хүснэгт 11. Хүн амын тоо 18
Хүснэгт 12. Малын тоо, /мян.төг/....18
Хүснэгт 13. Малтай өрхийн тоо 18
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын дүн 21
Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ 25
Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө....31
Хүснэгт 17. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө....31
Хүснэгт 18. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө....33
Хүснэгт 19. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө....37
Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 31
Хүснэгт 21. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 33
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг 4
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал 5
Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/ 7
Зураг 4. Төслийн талбайн бүс бүслүүрийн зураг 7
Зураг 5. Төслийн талбайн физик газарзүйн мужлалын зураг 8
Зураг 6. Төсөл хэрэгжих талбайн зураг /карьер/ 9
Зураг 7. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал 10
Зураг 8. Төслийн талбай орчмын усны сав газар 11
Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын хөсрөн бүрхэвчийн хэв шинж 13
Зураг 10. Хотгор уурхайн талбайн ургамалжлын зураг 15
Зураг 11. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банниковынхоор) 16
Зураг 12. Төслийн талбай орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг 16
Зураг 13. Төслийн талбай орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг 17
Зураг 14. Төслийн талбайн агаарын чанарын мониторинг хийх цэгийн байршил 39
Зураг 15. Төслийн талбайн хөрс, ургамлан нөмрөгт мониторинг хийх цэгийн байршил 40
Зураг 16. Усны чанарт хяналт хийх цэгийн байршил 40

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр - "Нүүрст хотгор" нэртэй чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төслийн байршил - "Нүүрст хотгор" нэртэй чулуун нүүрсний орд нь Увс аймгийн баруун хэсэгт Бөхмөрөн сумын нутагт орших бөгөөд Увс аймгийн төв Улаангом хотоос баруун урд зүгт 140 км-т, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 1450 км-т, Бөхмөрөн сумын төвөөс зүүн хойд зүгт 40 км-т, Баян Өлгийн аймгийн Ногоон-нуур сумын нутагт орших Асгатын мөнгөний ордоос зүүн зүгт 60 км-т, Баян-Өлгийн аймгийн төв Өлгий хотоос зүүн хойд зүгт 133 км-т байрлаж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Улсын бүртгэлийн дугаар	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
1	"Хотгор" ХХК	0211005150	MV-001441	Баян-Өлгий аймаг, 7-р баг, Хотгор
			MV-014442	
			MV-020853	

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Талбайн хэмжээ, га
MV-001441			
1	49^0 50' 50.77"	90^0 54' 09.02"	39.2
2	49^0 50' 50.77"	90^0 53' 44.01"	
3	49^0 51' 01.77"	90^0 53' 44.01"	
4	49^0 51' 01.77"	90^0 53' 49.01"	
5	49^0 51' 07.77"	90^0 53' 49.01"	
6	49^0 51' 07.77"	90^0 54' 24.02"	
7	49^0 50' 51.76"	90^0 54' 24.02"	
8	49^0 50' 51.76"	90^0 54' 09.02"	
MV-014442			
1	49^0 50' 51.78"	90^0 53' 29.02"	51.25
2	49^0 50' 51.78"	90^0 52' 36.71"	
3	49^0 51' 07.15"	90^0 52' 46.45"	
4	49^0 51' 09.78"	90^0 52' 54.63"	
5	49^0 51' 09.78"	90^0 53' 29.02"	
MV-020853			
1	49^0 51' 01.77"	90 53' 44.01"	55.62
2	49^0 50' 50.77"	90^0 53' 44.01"	
3	49^0 50' 50.77"	90^0 54' 09.02"	
4	49^0 50' 49.77"	90^0 54' 15.01"	
5	49^0 50' 46.76"	90^0 54' 14.02"	
6	49^0 50' 44.77"	90^0 54' 24.02"	
7	49^0 50' 32.77"	90^0 54' 20.02"	
8	49^0 50' 44.77"	90^0 53' 28.01"	
9	49^0 50' 46.2"	90^0 53' 29.02"	
10	49^0 51' 07.77"	90^0 53' 29.02"	
11	49^0 51' 07.77"	90^0 53' 49.01"	
12	49^0 51' 01.77"	90^0 53' 49.01"	

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг



Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал

1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Нүүрст хотгорын чулуун нүүрсний ордын MV-001441, MV-014442, MV-020853 тоот тусгай зөвшөөрлийн талбай дахь ил уурхайн нь эхний жилдээ 110 мян.тн, 2 дахь жилээс эхлэн орон нутгийн нүүрсний хэрэглээтэй уялдан 130 мян.тн нүүрс олборлоно.

Хүснэгт 3. , MV-014442, MV-020853 тоот тусгай зөвшөөрлийн талбай дахь анх батлагдсан нөөцийн хэмжээ

Давхраас	Нөөцийн блок	Геологийн нөөц, мян.тн			
		Баттай нөөц (A)	Бодитой нөөц (B)	Боломжтой нөөц (C)	Бүгд
MV-001441					
IV	7B	-	1,175.03	-	1,175.03
	8B	-	162.25	-	162.25
	9B	-	1,560.92	-	1,560.92
Нийт		**-**	**2,898.20**	**-**	**2,898.20**
MV-014442					
III	1A	588.34	-	-	588.34
	2B	-	558.16	-	558.16
	3B	-	499.32	-	499.32
IV	1A	2,598.12	-	-	2,598.12
	2A	2,840.79	-	-	2,840.79
	6B	-	1,908.22	-	1,908.22
Нийт		**6,027.25**	**2,965.70**	**-**	**8,992.95**
MV-020853					
III	3C			250.40	250.40
	4C			620.30	620.30
	5C			48.77	48.77
IV	2A	550.73			550.73
	3A	1,641.49			1,641.49
	6A	224.56			224.56
	7B		2,405.71		2,405.71
	8B		1,219.67		1,219.67
	10C			3,004.89	3,004.89
VI	2C			48.19	48.19
VII	2C			420.64	420.64
Нийт		**2,416.78**	**3,625.38**	**4,393.19**	**10,435.36**
Бүгд А нөөц		**8,444.04**			**8,444.04**
Бүгд В нөөц			**9,489.28**		**9,489.28**
Бүгд С нөөц				**4,393.19**	**4,393.19**
Бүгд		**8,444.04**	**9,489.28**	**4,393.19**	**22,326.51**

Хүснэгт 4. Нүүрст хотгорын ил уурхайн уулын ажлын төлөвлөлт

№	Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт, $м^3$	Нүүрс олборлолт		Уулын цулын хэмжээ, $м^3$
			тн	$м^3$	
1	1	266,511	107,571	76,836	343,347
2	2	324,485	130,098	92,927	417,412
3	3	328,136	130,134	92,953	421,089
4	4	323,416	129,473	92,481	415,897
5	5	318,980	131,523	93,945	412,925
6	6-10	1,562,277	648,880	463,486	2,025,763
8	Нийт	3,123,805	1,277,679	912,628	4,036,433

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ

"Нүүрст хотгор" нэртэй чулуун нүүрсний орд нь Увс аймгийн баруун хэсэгт Бөхмөрөн сумын нутагт орших бөгөөд Увс аймгийн төв Улаангом хотоос баруун урд зүгт 140 км-т, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 1450 км-т, Бөхмөрөн сумын төвөөс зүүн хойд зүгт 40 км-т, Баян Өлгийн аймгийн Ногоон-нуур сумын нутагт орших Асгатын мөнгөний ордоос зүүн зүгт 60 км-т, Баян-Өлгийн аймгийн төв Өлгий хотоос зүүн хойд зүгт 133 км-т байрлана.

Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/



2.2. ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Алтайн уулархаг их мужийн Монгол-Алтайн уулархаг мужийн Хархираагийн салбар уулсын бүсэд хамаарагдах ба Ачит нуур, Үүрэг нуурын хотгорын хооронд орших Байрамын нурууны урд бэлд оршино.

Байрам нуруунаас урагшаа буюу зүүн урагшаа Ачит нуурын хотгорын зүүн хойд талаар байрлах дунд зэргийн өндөрлөгтэй уулс нь ихэвчлэн урагшаа, зүүн урагшаа сунаж тогтсон 2000-2400 м-ийн дундаж өндөртэй уулс нь шовх оройтой, огцом хэрчигдэлтэй, гуу жалгууд нь эхэндээ маш нарийхан, хавцал маягтай гол төлөв "V" хэлбэртэй, адаг руугаа өргөснө.

Зураг 4. Төслийн талбайн бүс бүслүүрийн зураг



Зураг 5. Төслийн талбайн физик газарзүйн мужлалын зураг



Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужид, Газарзүйн бүсчлэлээр хээрийн бүсэд тус тус багтаж байна.

Төслийн талбай нь Бөхмөрөн сумын Хар-Алтад багийн нутаг дэвсгэрт, тус сумын зүүн урд хэсэгт байрлаж байна. Газрын гадаргын төрх байдал нь үндсэндээ байгалийн төрх байдлаа алдсан, хүн, техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд өртсөн байна.

2.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГАЗРЫН ГАДАРГА

Төслийн талбай нь зүүн хойд талаар уул толгод, ухаа гүвээтэй, дунд хэсэг нь олборлолтонд өртсөн, баруун өмнөд хэсгээрээ тэгш хөндий гадаргатай, далайн түвшнээс дээш дунджаар 2055 метр өндөрт өргөгдсөн байна.

"Хотгор" ХХК-ийн Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт байрлах Нүүрст Хотгор нэртэй чулуун нүүрсний ордын нийт талбай нь 146.07 га бөгөөд үүнээс уурхай 82.4 га, технологийн зам 3.2 га, автопүү, шалган нэвтрүүлэх талбай 1.58 га, тэсрэх материалын агуулах 1.31 га, нийт 88.43 га нь эвдрэлд өртөхөөр байна.

Зураг 6. Төсөл хэрэгжих талбайн зураг /карьер/

2.4. УУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙ ШИНЖ, ОНЦЛОГ

Увс аймгийн жилийн дундаж температур -1.4^{0}С. Орон зайн тархалтаар авч үзвэл нутгийн өндөрлөг баруун хойд хэсгээр -10^{0}С-аас -6^{0}С, дунд хэсгээр -8^{0}С-аас -4^{0}С, өмнөд хэсгээр -2^{0}С-аас 0^{0}С дулаан байдаг (Монгол орны уур амьсгалын шинэчилсэн стандарт норм, 2021).

Жилийн дунджаар 153 мм хур тунадас унадаг. Орон зайн тахралтаар авч үзвэл нутгийн өндөрлөг баруун хойд болон ХанХөхий салбар уулсын хэсгээр 200-270 мм, өмнөд Хар-Ус, Завхан, Наранбулаг сум орчмоор 100-150 мм, бусад нутгаар буюу нам дор нууруудын сав орчмоор 100-150 мм хур тунадас унадаг байна (Монгол орны уур амьсгалын шинэчилсэн стандарт норм, 2021).

Увс аймгийн газрын гадаргад тусч байгаа шууд, сарнимал цацрагийн нийлбэр /нийлбэр цацрагийн/ хэмжээ нутгийн хойд хэсэгт жилдээ 115 ккал/см^2, өмнөд хэсэгт 120 ккал/см^2, Бөхмөрөнд 118.4 ккал/см^2 болно. Цацрагийн балансын жилийн нийлбэр дунджаар 38-42 ккал/см^2, Бөхмөрөнд 39.8 ккал/см^2 байна. Цацрагийн баланс 11-1 дүгээр сард хамгийн бага цацрагийн алдагдалтай хасах 0.3-0.6 ккал/см^2, зуны саруудад хамгийн их 6.8-7.7 ккал/см^2 байдаг. Бөхмөрөнд доод үүлшлээр наргүй байх өдөр 18 байдаг.

Бөхмөрөн сумын орчмоор агаарын температурын олон жилийн дундаж /ОЖД/ нь -1.9ºС бөгөөд сүүлийн таван жилийн /2016-2021он/ агаарын температурын хандлагын өөрчлөлтийг боловсруулж үзэхэд: сүүлийн жилүүдэд агаарын дундаж температур утга -1.5ºС, ОЖД-аас 0.4^0С-р дулаарсан ажиглагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хандлага нь сүүлийн зургаан жилд дунджаар 0.21^0С-аар буюу алгуур тасралтгүй өсөлттэй ажиглагдаж байна.

Бөхмөрөн сумын орчмоор ОЖ-ийн дунджаар жилдээ 146.5 мм хур тунадас ордог. Сүүлийн таван жилийн дунджаар 167.9 мм хур тунадас орсон байгаа ОЖ-ийн дунджаас 21.4 мм ахиу хур бороо сүүлийн жилүүдэд орсон. Сүүлийн таван жилийн тунадасны хэмжээг нэмэгдэх болсон нөхцөл нь 2019 оны 7 дугаар сард 132.5 мм орсон нь түүхэнд бичигдэх 2 дах рекорд болсон байна.

Харин ууландаа цас эрт ордог бөгөөд өндөр уулын бүсэд анхны цас олон жилийн дунджаар 8-р сарын эхний 10 хоногт, эцсийн цас 6-р сарын эхний 10 хоногт орж байна. Энд жилийн бараг 188-200 хоногт нь цасан бүрхүүлтэй байна. Харин уулын хээр, ялангуяа говийн бүсэд тогтвортой цасан бүрхүүл бараг тогтдоггүй, тогтсон ч 24-50 хоногоос хэтэрдэггүй юм.

2.5. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ЧАНАР

Тус чулуун нүүрсний орд орчимд агаарын тоосжилт, чанарыг Temtop LKC-1000, дуу чимээг MS6300 Environment Multimeter багажуудыг ашиглаж тодорхойлсон.

Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн

Цэгийн дугаар	Хэмжилт хийсэн байршил	AQI	PM 2.5 (ug/m^3)	PM10 (ug/m^3)	HCHO (mg/m^3)	TVQC (mg/m^3)	Хэмжилт хийсэн цэгийн координат
1	Уурхайн тосгоны зүүн урд талд	7	1.7	3.1	0.01	0.04	49°51'10.18" 90°53'19.53"
2	Уурхайн аман дээр	4	1.1	1.4	0.01	0.06	49°51'11" 90°53'32"
3	Тэсрэх материалын агуулах	17	2.4	2.3	0.01	0.05	49°51'16" 90°54'03"
4	Уурхайн дотор	487	323.8	576.0	0.013	0.15	-
5	2022 онд Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	9	2.8	4.1	0.01	0.17	49°51'06" 90°53'14"
6	Аюултай хог хаягдлын цэгт	11	3.0	5.1	0.01	0.04	49°51'11" 90°53'39"
7	Уурхайн баруун урд талд хөрсний овоолгын хажууд	9	2.5	3.3	0.02	0.10	49°51'00" 90°52'59"
8	Уурхайн зүүн урд талд	53	12.9	24.2	0.01	0.07	49°50'49" 90°54'11"
9	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	14	3.0	5.4	0.04	0.20	49°50'53" 90°54'24"

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад зааснаар уурхайн олборлолт явагдаж буй хэсэгт буюу Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангиллаар бохирдол өндөр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээр түвшинд байна. Харин уурхайн ухлагаас гаднах талбайд хийсэн хэмжилтийн дүнгээс харахад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд гарсан байна.

Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт: Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад **PM2.5** 1.1 – 323.8 мг/м^3 , **PM10** 1.4 – 576.0 мг/м^3 утгатай гарч байв. Агаарын чанарын стандарт MNS 4585 : 2016 -д PM2.5 - 50 мг/м^3 , PM10 - 100 мг/м^3 гэж заасан байна. Энэхүү утга нь тухайн үеийн нэг хэмжилтийн утга болно. Хэмжилтийн явцад гадаад орчны температур 17° С – 25 ° С, агаарын чийгшил 25 % - 39 % байв.

Зураг 7. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал

2.6. Усан орчин

Төслийн талбай нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 тоот тушаалаар баталсан Монгол орны 29 усны сав газраас Хар нуур-Ховдын сав газарт хамаарагдана. Төслийн талбайн захын цэгээс Байрмын хэв гол хүртэл 300 м зайтай байна.

Зураг 8. Төслийн талбай орчмын усны сав газар



Төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуйн усаа уурхайгаас зүүн урд зүгт ойролцоогоор 5 км-ийн зайд урсах Ямаатын голоос зөөврөөр авч хэрэглэнэ. Харин уурхайн тоосжилт дарах болон ногоон байгууламжийн усалгааг ажилчдын кемп дээр байрлах гүний худгаас авна.

Хүснэгт 6. "Хотгор"ХХК-ний гүний худгийн усны шинжилгээний дүн

Катион	1 дм^3			Анион	1 дм^3		
	Мг/л	Мг-экв/л	Мг-экв/%		Мг/л	Мг-экв/л	Мг-экв/%
Ca^{++}	188.00	9.38	38.29	CO_3^-	0.00	0.00	0.00
Mg^{++}	173.00	14.23	58.08	HCO_3^-	1291.00	21.16	86.35
Fe	0.00	0.00	0.00	Cl^-	28.00	0.79	3.22
K^+	4.00	0.10	0.42	SO_4^-	94.00	1.96	7.99
Na^+	18.00	0.78	3.20	NO_3^-	37.00	0.60	2.44
Дүн	**3.83**	**24.50**	**100.00**	**Дүн**	**1450.00**	**24.50**	**100.00**

Хүснэгт 7. Ямаатын голын усны унд ахуйн шинжилгээний дүн

Анион	1 дм^3			Катион	1 дм^3		
	Мг	Мг-экв	Мг-экв/%		Мг	Мг-экв	Мг-экв/%
Cl^-	4.6	0.13	7.6	$Na^+ + K^+$	10.7	0.47	27.3
SO_4^-	18.0	0.38	22.0	Ca^{++}	20.0	1.00	58.7
$NO2^-$	0.00	0.00	0.0	Mg^{++}	2.9	0.24	14.1
NO_3^-	0.0	0.00	0.0	NH_4^+	0.0	0.00	0.0
CO_3^-	12.0	0.40	23.5	Fe^{++}	0.0	0.00	0.0
HCO_3^-	48.8	0.80	46.9	Fe^{+++}	0.0	0.00	0.0
Дүн	**83.4**	**1.71**	**100.0**	**Дүн**	**33.7**	**1.71**	**100.0**

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хотгор нүүрсний орд нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Монгол Алтайн мужийн Хархираа-Түргэний хөрсний тойрогт хамаарагдах бөгөөд энд нөлөөлөлд их бага хэмжээтэй өртсөн сайр чулуурхаг, элсэнцэр хар хүрэн

хөрснүүд зонхилох талбайг эзэлнэ. Харин өндөр уулын хэсгээр чулуурхаг хар хүрэн, хүрэн хөрс, голуудын хөндий татмаар аллювийн ширэгт, хайргархаг хөрс тус тус тархсан байна

Тус ашиглалтын талбайд нөлөөлөлд их, бага хэмжээтэй өртсөн сайр чулуурхаг, элсэнцэр хар хүрэн хөрснүүд зонхилох талбайг эзэлнэ. Харин өндөр уулын хэсгээр чулуурхаг хархүрэн, хүрэн хөрс, голуудын хөндий татмаар аллювийн ширэгт, хайргархаг хөрс тус тус тархсан байна.

Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын хөсрөн бүрхэвчийн хэв шинж



2.8. ХӨРСНИЙ ХИМИ, ФИЗИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хээрийн судалгааг 2023 оны 08-р сарын 17-ны өдөр хийж гүйцэтгэсэн бөгөөд хөрсний хүнд металлын бохирдол болон хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтүүд, хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав. Хөрсний лабораторийн шинжилгээний дүнгээр тус нэгж талбарын хөрс нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 8. Хөрсний химийн үндсэн шинжийн үзүүлэлтүүд

№	Дээж авсан гүн, см	pH	ЦДЧ,dsm	Давс, %	Ялзмаг %	NO_3, мг/100г	Солилцох суурь, мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca+Mg	Ca	Mg	P_2O_5	K_2O
MV-001441											
1	0-20	8.22	0.327	0.139	3.26	1.34	28	16	12	4.2	6
2	20-40	7.60	0.128	0.054	4.98	0.43	42	32	10	4.2	8
MV-014442											
1	0-20	8.10	0.120	0.051	3.39	0.73	27	18	9	5.3	12
2	20-40	7.95	0.049	0.049	2.87	0.51	27	17	10	3.5	12
MV-020853											
1	0-20	8.48	0.101	0.043	1.79	0.47	21	17	4	3.5	10
2	20-40	8.45	0.100	0.043	1.84	0.042	20	12	8	3.6	14

Хар хүрэн хөрстэй, газрын гадаргын өнгөн хөрс нь тоосорхог, цайвар шаргал өнгөтэй, жижиг үйрмэг чулуутай, бөөмөрхөг бүтэцтэй, ургамлын үндэс багавтар, сийрэг нягттай, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж-ний дугаар	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
MV-001441								
1	0-20	38.6	32.5	12.4	7.3	3.6	5.6	16.5
2	20-40	25.7	46.1	4.6	13.6	0.5	9.5	23.6
MV-014442								
1	0-20	29.4	44.5	3.2	15.7	2.6	4.6	22.9
2	20-40	26.5	46.2	6.1	11.6	3.7	5.9	21.2
MV-020853								
1	0-20	25.4	44.1	5.4	15.9	3.8	5.4	25.0
2	20-40	27.3	44.2	9.5	8.0	1.2	9.8	19.0

2.9. ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН БОХИРДОЛ

MV-001441, MV-014442, MV-020853 лицензийн 3 талбайн хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад 0-20 см-ийн гүнээс авсан дээжинд хар тугалга, цайр, зэс , хром, никель зэрэг хүнд металиуд зохих хэмжээнд ирсэн бөгөөд харин кадми илрээгүй байна. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
MV-001441							
1	0-20	10.7	0.0	28.1	74.7	49	9.1
2	20-40	9.3	0.0	31.3	70.6	50	11.7
MV-014442							
1	0-20	13.6	0.0	40.7	102.0	49	19.2
2	20-40	16.5	0.0	40.7	99.1	45	23.4
MV-020853							
1	0-20	20.0	0.0	46.9	74.5	40	27.7
2	20-40	14.3	0.0	46.9	74.5	51	24.0
Элсэрхэг хөрс		60	1	50	100	60	60
Шавранцар хөрс		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс		150	3	100	300	150	100

Хүснэгт 10. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS6341:2012	Гэдэсний савханцарын титр (E.coli) MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS6341:2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
MV-001441						
1	Дээж 3	$8.1*10^5$	1	1	0.1<	1
MV-014442						
1	Дээж 1	$7.9*10^5$	1	1	0.1<	1
MV-020853						
1	Дээж 2	$7.5*10^5$	1	1	0.1<	1

2.10. УРГАМЛАН НӨМРӨГ

Уурхайн орд газрын зориулалтаар ашиглах 146.07 га талбайд хээрийн судалгаа явуулахад ургамалжилтын хувьд талбайн зүүн хойд талаар уул толгод, ухаа гүвээтэй, дунд хэсэг нь олборлолтонд өртсөн, баруун өмнөд хэсгээрээ цөлөрхөг хээрийн тэгш хөндийн ургамалжилттай ба нийт 20 овогт хамаарах 49 төрөл, 63 зүйл ургамал байна.

Хэвшинж	Хэвшил	Бүлгэмдэл
Цөлөрхөг хээр	Харганат	Харгана- үетэнт
Нуга	Үетэнт	Харгана бүхий Үетэнт
Мод тарьсан талбай		

Зураг 10. Хотгор уурхайн талбайн ургамалжлын зураг



2.11. АМЬТНЫ АЙМАГ

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Ачит нуурын хотгор нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар (А.Г.Банников 1954) Хойд говийн тойрогт хамрагдах бөгөөд энэ тойргийн хамгийн баруун хойд цэг нутаг болдгоороо өвөрмөц онцлогтой байдаг.

Зураг 11. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банниковынхоор)



1.Хөвсгөл орчмын тойрог
2. Хэнтийн тойрог
3. Баруун Хянганы тойрог
4. Монгол Дагуурын тойрог
5. Хангайн тойрог
6. Баруун хойд Монголын тойрог
7. Хойд говийн тойрог
8. Говь-Алтайн тойрог
9. Алтайн өвөр говийн тойрог

Судалгааны талбай орчмын нутагт хөхтөн амьтдаас шавьж идэштэн 4, гар далавчтан 5, туулайтан 4, мэрэгчтэн 17, зараатан 1, туруутан 1 зүйл нийт 41 зүйлийг бүртгэн тэмдэглэсэн байна.

Энэ нутагт 11 багт хамаарах 47 зүйл шувууд тархан амьдардаг болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. Энд говь цөлийн, хуурай хээрийн, ус намгархаг газрын зэрэг өвөрмөц биотопуудад амьдардаг шувууд тохиолдоно. Эдгээрээс CITES-ийн конвенцийн I хавсралтад 4 зүйл, II хавсралтад 8 зүйл, CMS-ийн конвенцийн хавсралтад 10 зүйл, Азийн "Улаан ном"-д 2 зүйл бүртгэгдсэн байна.

Нүүрст хотгор орчим хоёрнутагтан байдаггүй бөгөөд мөлхөгчдөөс 2 зүйл гүрвэл, 2 зүйл могой тохиолдоно. Цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт. Эдгээр зүйлүүд Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан дансанд анхааралд өртөхөөргүй ангиллаар үнэлэгдсэн байдаг.

2.12. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Төслийн талбай нь Увс нуурын ай сав Түргэн уулын хэсэг Дархан цаазат газрын орчны бүсэд байрлаж байна.Төсөл хэрэгжих талбай орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Зураг 12. Төслийн талбай орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг



Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих талбайгаас баруун зүгт Гулзат /Аймгийн ОНТХГ/ гэх газар нь 9.3 км, хойд зүгт Байрам уул /Сумын ОНТХГ/ нь 2 км, зүүн урд зүгт Олон ямаат /Сумын ОНТХГ/ нь 11.2 км, баруун урд зүгт Ачит нуур-Бөхмөрөн /Сумын ОНТХГ/ нь 7.5 км зайтай байрлаж байна. Төслийн талбай нь ОНТХГ нутагтай давхцалгүй байрлана.

Зураг 13. Төслийн талбай орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг



2.13. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Увс аймгийн Бөхмөрөн сум нь 1924 оны намар байгуулагдсан. Далайн түвшнээс дээш 1498 м өргөгдсөн эрс тэс уур амьсгалтай. Бөхмөрөн сум нь Хархираа, Түргэн, Байрмын уулс, Сийлхэмийн

нуруу, Бөхмөрөн голын сав, Ачит нуурын хоорондох тэгш тал, цав толгод, уулс нуруу бүхий уудам нутгийг эзэлдэг. Тус сумын нутаг нь говь, тал хээр, хангай, алтайн өндөр уулархаг хэсгийн аль алины нь шинжийг хадгалж тогтсон нуур, гол, булаг шандаар элбэг юм. Тус сум нь Увс аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 1580 км, Аймгийн төвөөс 180 км зайд байрладаг. Оросын холбооны улсын Бүгд Найрамдах Тува улс, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум, Увс аймгийн Түргэн, Сагил, Ховд, Тариалан сумдтай хиллэдэг.

Хүснэгт 11. Хүн амын тоо

Засаг захиргааны нэгж	Насны бүлэг	2019 он	2020 он	2021 он	2022 он
Бөхмөрөн сум Хар-Алтад баг	Бүгд	794	792	786	783

Хүснэгт 12. Малын тоо, /мян.төг/

Засаг захиргааны нэгж	Малын төрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он
Бөхмөрөн	Бүгд	147.539	147.636	146.517	121.65
	Адуу	5.27	5.78	6.395	6.004
	Үхэр	7.935	9.295	10.168	9.562
	Тэмээ	0.124	0.116	0.123	0.117
	Хонь	63.98	64.79	64.187	50.452
	Ямаа	70.23	67.655	65.644	55.515

Хүснэгт 13. Малтай өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	Баг, хорооны код	2019 он	2020 он	2021 он	2022 он
Увс аймаг	185	13040	13250	13460	13480
Бөхмөрөн сум	18507	500	500	510	500
Хар-Алтад баг	1850753	180	180	180	180

Эх үүсвэр : 1212.mn

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. ТӨСЛӨӨС ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

- Ил уурхай, овоолго, зам, бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх;
- Уурхай ухаш, овоолго, зэргийг байгуулахад газрын хэвлийг эвдэх;
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх;
- Ил уурхай, уурхайн суурингийн обьектууд, агуулах зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах зэрэг сөрөг нөлөөтэй.

3.2. АГААРЫН ЧАНАРТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Сайжруулаагүй зам эсвэл байгалийн шороон замаар тээврийн хэрэгсэл зорчих үед дугуйн даралтын хүчний үйлчлэлээр гадаргуун материал хэмхэрч нунтгардаг.

Тээврийн хэрэгсэл зорчин өнгөрөх үед түүний ард дагалдан үүсдэг агаарын хүчтэй турбулент хөдөлгөөний үйлчлэлээр замын гадаргуун материалын эгэл хэсгүүд хөдөлгөөнд орох эргэлдэж буй дугуйгаар зарим хөрсний эгэл хэсгүүд дээш өргөгдөөд, доош унах зэргээр тоосжилт үүсдэг.

3.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

ТЭЗҮ –д дурдсанаар төсөл хэрэгжих 5 жилд 1561.5 мян.м^3 үндсэн хөрс хуулалт, 449.14 мян.м^3 (628.79 мян.тн) нүүрс олборлолтын ажил гүйцэтгэнэ. Нийт 88.43 га талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулах;

Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах, хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсэх

Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон усаар угаагдаж элэгдэх

Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

3.4. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих үед ургамлан бүрхэвч талхлагдах, ил уурхайн ургамлан нөмрөг устаж үгүй болох, барилгын материал, ачаа бараанд дарагдах, тоос шороонд булагдах, тоосжих, бохирдох зэрэг үзэгдлүүд бий болно.

Эдгээр сөрөг нөлөөллүүдээс болж ургамлын төрөл зүйл цөөрөх, бүрхэц арив багасах, ургацын хэмжээ, шимт чанар муудах, ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж талхагдлын шинж чанарыг илтгэгч төрөл бүрийн шарилж, лууль, шаваг, хамхуул мэтийн хөл газрын ургамал өндөр бүрхэцтэйгээр түрэн орж ирэх үзэгдэл ажиглагдана. Гэхдээ энэ нь түр зуурынх бөгөөд нөхөн сэргээх боломжтой.

3.5. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Уг төслийн үйл ажиллагаанаас усан орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл нь уурхайн ус ашиглалт байна.

Уурхайн унд ахуй болон технологийн зориулалтаар ус ашиглалтаас газрын доорх усны нөөц болон уст үед тодорхой хэмжээний өөрчлөлт оруулна.

Уурхайн дотоод хяналт сулрах, санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар хөрсөнд шатах тослох материал болон хатуу хаягдлууд алдагдах нь хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй.

3.6. АМЬТНЫ АЙМАГТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах;
- Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон уурхайн тээврийн зам нь зарим амьтадын нүүдэлд сөрөг нөлөө үзүүлнэ;

- Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

"Нүүрст хотгор" нүүрсний ордыг ашиглах төслийн БОМТ-г Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", "Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал"-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, зэргийг удирдлага болголоо.

"Хотгор" ХХК-ийн "Нүүрст хотгор нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах" төслийн хүрээнд 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд **51.3 сая**.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

Энд тусгагдаагүй зардлууд нь Бөхмөрөн сумтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ -тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын дүн

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал (2025 он)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	сая.төг	10.47
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	сая.төг	19.09
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	сая.төг	4.83
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	сая.төг	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	сая.төг	7.66
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	сая.төг	3.20
7	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	сая.төг	6.04
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	сая.төг	-
	Дүн	**сая.төг**	**51.3**

3.7. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН					
Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлөх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	ҮАЗ-д тусгах		2025 онд	MNS3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага” MNS3384:1982 “Агаар мандалАгаарын дээжлэлт шинжилгээ” MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх
	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах	3500.0	3500.0	2025 онд	
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	1000.0	1000.0	2025 онд	
Нүүрс тээвэрлэх үед хүнд даацын машин механикийн хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Дотоод тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	1500.0	1500.0	2025 онд	
	Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох	ҮАЗ-д тусгах		2025 онд	
Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын	ҮАЗ-д тусгах		2025 онд	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх				бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990-2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	ҮАЗ-д тусгах		2025 онд	
Дүн		**6000.0**			
УСАН ОРЧИН					
Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэж газрын доорх усхомсдох	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж,гэрээ хийж,гэрчилгээ авч ажиллах	ҮАЗ-д тусгах		2025 онд	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ; MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага; MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх; MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох; MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн
	Усны эх үүсвэрийг 2013.05.16-ны өдрийн БОНХЯ-ны Сайдын а/156 тоот “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах” журмын дагуу тоолууржуулж, усны төлбөр тооцоог тоолуурын заалтыг үндэслэж тооцоолох.Тоолуурыг орон нутгийн мэргэжлийн байгууллагаар суурилуулж,байгаль орчны улсын байцаагчтай акт хөтөлж ажиллах	ҮАЗ-д тусгах		2025 онд	
